



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМАНД “ХАДАТ” НЭРТЭЙ ГАЗАРТ
ОРШИХ БАРИЛГЫН ЧУЛУУ ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН ТУХАЙН ЖИЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН 2022**



ГАРЧИГ

ОРШИЛ	4
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн нэр	5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч	5
1.3. Төслийн байршил	5
1.4. Орд ашиглах тусгай зөвшөөрөл	6
1.5. Ордын нөөц	6
1.6. Төслийн хүчин чадал	7
1.7. Уурхайн ажиллах горим	7
1.8. Тоног төхөөрөмж	7
1.9. Тэсэлгээний ажил	7
1.10. Ухаж ачих процесс	8
1.10.1. Уурхайн тээвэрлэх процесс	8
1.10.2. Овоолох процесс	8
2.11. Бутлан-ангилах хэсгийн технологи сонголт	8
2.11.1. Бутлан-ангилах хэсгийн технологийн горим	8
1.12. Цахилгаан хангамж	8
1.13. Аянгаас хамгаалах байгууламж	8
1.14. Усан хангамж	9
БҮЛЭГ 2. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
3.3. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	16
3.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
3.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18
3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
3.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	23
3.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	25
3.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
3.10.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний үр дүн	28
3.10.3. Усны чанарын хяналт шинжилгээ ба түүний үр дүн	28

3.10.3. Хөрсний чанарын хяналт шинжилгээ ба түүний үр дүн	28
4. 2021 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ	29
Хавсралт материал	30

ХҮСНЭГТИЙН ДУГААРЛАЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	5
Хүснэгт 2. Талбайн солбицол	6
Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим	7
Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн жагсаалт	7
Хүснэгт 5. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ	9
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах талбайн координат	16
Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 10. Олон нийтэд танилцуулах төлөвлөгөө	25
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
Хүснэгт 12. Агаарын шинжилгээний үр дүн 1-р	28
Хүснэгт 13. Хөрсний шинжилгээний үр дүн 1-р	28

ЗУРГИЙН ДУГААРЛАЛТ

Зураг 1. Төслийн байршлын зураг	6
Зураг 2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 5-р заалтын биелэлт	14
Зураг 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 4-р заалтын биелэлт	15
Зураг 4. Дүйцүүлэн хамгаалах талбайн зураг	17
Зураг 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт	19
Зураг 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 5-р заалтын биелэлт	20
Зураг 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 6-р заалтын биелэлт	20
Зураг 8. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажилчдад олгосон байдал	21
Зураг 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт	23
Зураг 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
Зураг 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт	25

ОРШИЛ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилтыг хангах үүднээс БОАЖЯ-наас байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулна.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь барилгын чулууны ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн хэрэгжүүлэн ажиллана.

Тус компани Монгол Улсын холбогдох хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-г 2019 онд мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэсэн бөгөөд түүний зөвлөмж, заалтын хэрэгжилтийг ханган ажиллана.

“Уулс ноён” ХХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагын тэнцвэрийг олох зарчмаар тогтвортой хөгжлийг дэмжих үүрэг хүлээсэн билээ. Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажиллана.

- Байгаль орчны удирдлагын ISO14001 стандартад нийцсэн байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагааны байнгын хяналт, ахиц дэвшлийг ханган ажиллана.
- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учирах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авсан.
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлнэ.
- Ашигт малтмалын хайгуул хийх, барилга байгууламж барих, уурхайн олборлолт хийх зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлнэ.
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулна.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулна;
- “Уулс ноён” ХХК өөрийн үйл ажиллагаа болоод төслийн цар хүрээ, нөхцөл байдал хоорондын бодит уялдаа холбоог хангах үүднээс үйл ажиллагааны тогтолцоонд тодорхой хугацаанд хяналт тавьж ажиллана.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	
2	Улсын бүртгэлийн дугаар	
3	Уурхайн нэр	
5	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг
6		Сум/Дүүрэг
7	Ашигт малтмалын төрөл	
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	
9	Ашиглалт эхэлсэн огноо	
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот
11		Сум/Дүүрэг
12		Баг/Хороо
13		Гудамж/Байр
14		Шуудангийн хайрцаг
15	Утас	
16	Факс	
17	Гар утас	
18	Электрон шуудан	
19	Вэб хуудас	
20	Захирлын хаяг	Нэр
21		Гар утас
22		Факс
23		Утас
24		Электрон шуудан

1.1. Төслийн нэр

Дархан-уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт орших “Дарханы барилгын чулууны ордын Хадат хэсгийн барилгын чулууны орд”-ыг ил аргаар ашиглах төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Уулс ноён” ХХК нь 2007 онд уул уурхайн бусад олборлох үйл ажиллагаа, худалдаа үйлчилгээ, худалдааны зуучлал, газрын хэвлийн нөхөн сэрэгээлт зэрэг чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын 1911010057 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 2868687 тоот регистрийн дугаартай.

1.3. Төслийн байршил

“Дарханы барилгын чулууны ордын Хадат хэсгийн барилгын чулууны орд” нь Дархан-Уул аймгийн нутаг харьяалагдах ба Улаанбаатар хотоос хойш 235 км, Дархан хотоос зүүн хойш 5 км-т байрладаг.

Хүснэгт 2. Талбайн солбицол

№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	106	00	34	49	31	25
2	106	01	08	49	31	25
3	106	01	08	49	31	11
4	106	00	34	49	31	11



Зураг 1. Төслийн байриллын зураг

1.4. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Дархан-уул аймгийн засаг даргын тамгын газраас “Уулс Ноён” ХХК-д 29.56 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож ДА-005А дугаар бүхий гэрчилгээг 2019 оны 06 сарын 03-ны өдөр олгосон.

“Уулс ноён” ХХК нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт орших “Дарханы барилгын чулууны ордын Хадат хэсгийн барилгын чулууны орд”-д 2018 онд геологи хайгуулын ажил, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө зэргийг боловсруулан АМГТГ-ын геологийн хэлтэс, ЭБМЗ-ийн 2019 оны 04 сарын 12-ны хурлаар орж батлуулсан.

УУХҮЯ, АМГТГГазар, ЭБМЗ-ийн хурлаар орж 2019 оны 6-р сарын 27-ны өдөр ТЭЗҮ-ийг батлуулсан.

1.5. Ордын нөөц

“Дарханы барилгын чулууны ордын Хадат хэсгийн барилгын чулууны орд” нь В+С зэргээр нийт 9 блок ялган тооцоолж В зэргээр 1828.3 мян.м³ дайрга, С зэргээр 4082.4 мян.м³ дайрга, нийт В+С зэргээр 5910.7 мян.м³ дайрганы нөөц баталгаажуулсан байна. Үүнээс уурхайн хүрээ хязгаарт В зэргээр 1709.05 мян.м³ дайрга, С зэргээр 406.16 мян.м³ дайрга, нийт В+С зэргээр 2115.21 мян.м³ дайрга хамрагдаж байна.

1.6. Төслийн хүчин чадал

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг Тейлорын томъёоллыг ашиглан тооцоход 1 жилийн хугацаанд 189.5 мян.тн дайрга олборлохоор байна. Төсөл хэрэгжүүлэгч “Уулс ноён” ХХК нь 2019 оноос Дарханы районд орон сууцны бүтээн байгуулалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийн хүчин чадлыг 100.0 мян.м³/жил дайрга олборлон борлуулахаар төлөвлөж, уурхайн хүчин чадлыг 100.0 мян.м³/жил-ээр төлөвлөж ТЭЗҮ-г мэрэгжлийн компаниар хийлгүүлсэн.

Дарханы барилгын чулууны ордын Хадатын хэсгийн барилгын чулууны орд” -н уурхайгаас 2022 онд 35,5 мян.м³ барилгын чулуу олборлон борлуулна. Ил уурхайн сар бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба сард хамгийн ихдээ 6,5 мян.м³ барилгын чулуу олборлохоор төлөвлөлөө.

1.7. Уурхайн ажиллах горим

Тус барилгын чулууны ил уурхайн 3-р жил буюу 2022 оны бэлтгэл ажлыг 05-р сарын 01-ээс эхлэн 11 сарын 01ны хооронд барилгын чулуу олборлохоор төлөвлөсөн ба уурхай нийт 133 хоног ажиллана. Уурхайн ажиллах хоногийг дараах байдлаар тооцоолов.

Хүснэгт 3. Ил уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Х.нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	184
2	Баяр ёслол	хоног	5
3	Амралт, засвар үйлчилгээ	хоног	28
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	152
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
6	Ээлжийн тоо	ш	1
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	10
8	Ээлжийн дэх сул зогсолт (цайны цаг, тос түлш нэмэх), цаг	цаг	1
9	Ээлжийн бэлтгэл, төгсгөл, цаг	цаг	1
10	Ээлжийн сул зогсолт	цаг	2
11	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	8
12	Цаг ашиглалт	-	0.89
13	Жилд ажиллах нийт цаг	мот/цаг	1216

1.8. Тоног төхөөрөмж

Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Төрөл	Марк	Нэгж	Тоо	Үзүүлэлт
1	Экскаватор	HITACHI 470	ш	1	2.6 м ³
2	Экскаватор	Hyundai 305 LC	ш	1	0.9 м ³
3	Автосамосвал	Howo	ш	2	25 тн
4	Дугуйт ачигч	LIUGONG	ш	1	2.7 м ³
6	Түлшний машин	Hino	ш	1	4000 л
7	Усны машин	Камаз	ш	1	6000 л
8	Бутлуур	Hebei Wanquangmine	ш	1	80 м ³ /ц

1.9. Тэсэлгээний ажил

2022 онд 2 удаа уурхайн тэсэлгээний ажил хийгдэх ба нийт 35,5 мянган м³ уулын цул тэсэлнэ.

1.10. Ухаж ачих процесс

Шимт хөрсийг бульдозероор түрж, дугуйт ачигчаар автосамосвалд ачиж шимт хөрсний овоолго руу тээвэрлэсэн. Шимт хөрсний овоолгыг 38° градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулсан. Шимт хөрсийг уурхайн талбай, овоолгын суурь, хүдрийн овоолго орчмын талбайгаас 0.8 метрийн зузаантайгаар хуулж гүйцэтгэсэн.

1.10.1. Уурхайн тээвэрлэх процесс

Уурхайн хөрс хуулалт, дайрга олборлолтонд ашиглах автосамосвалууд нь ил уурхайгаас хуулах хөрс болон олборлох дайргыг уурхайн гол замаар тээвэрлэж хөрсний хөрсний гадаад овоолго, дайргыг хүдрийн агуулах (түр овоолго) хүртэл тээвэрлэн хураана.

1.10.2. Овоолох процесс

Ил уурхайгаас гарах хөрсийг уурхайн өмнө талд орших гадаад овоолгод хураасан. Дайргыг уурхайн зүүн хойд талд уурхайн амнаас 710 м зайд бутлах үйлдвэрийн хажууд дайрганы овоолгод овоолж, шимт хөрсний овоолгыг тусад нь хураана.

2.11. Бутлан-ангилах хэсгийн технологи сонголт

Барилгын архитектур корпорац, Геологийн төв лабораториудад хийлгэсэн туршилтын үр дүн, адил төстэй барилгын чулууны ордын технологийг харьцуулан 2 шатны бутлалт, 2 шатны шигшилтийн технологийг сонгон ажиллана.

2.11.1. Бутлан-ангилах хэсгийн технологийн горим

Ил уурхайгаас ирсэн чулуулгийг урьдчиланшигшиж, шигшүүрийн дээд бүтээгдэхүүн хацарт бутлуурт орно. Шигшүүрийн доод бүтээгдэхүүнийг хоёр дахь шатны бутлуур луу өгнө.

Хоёр дахь шатны бутлуураар бутлагдсан чулуу хоёрдугаар шатны чичиргээт шигшүүр рүү орно. Хоёрдугаар шатны чичиргээт шигшүүрээс $-5+0$ мм, $-10+5$ мм, $-20+10$ мм, $+20$ мм-ээс дээш ширхэглэлтэй 4 ангиллын бүтээгдэхүүн гарсан бөгөөд $+20$ мм-ээс дээш ширхэглэлтэй бүтээгдэхүүн хоёрдугаар шатны бутлуур руу эргэлтийн ачаалал болж, битүү циклээр холбогдон ажиллаж байна. Шигшилт нь хуурай орчинд явагдана.

1.12. Цахилгаан хангамж

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Дарханы барилгын чулууны ордын Хадат хэсгийн барилгын ордыг ДСЦТС ХХК-ний эзэмшлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын боломжит цэгээс салбарлан, тус уурхай хүртэл 3.3 км үргэлжлэх 6.04 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татан, 6/0.4 кВ-т хүчдэлтэй 630 кВа-ын суурилагдсан хүчин чадалтай /ЦЭХА-ээр хангахаар төлөвлөн ажиллаж байна.

1.13. Аянгаас хамгаалах байгууламж

Уурхайн шатах тослох материалын агуулах болон засварын талбайг аянгын хамгаалалтын төхөөрөмж, түүнийг ашиглах журмын дагуу тэсрэх бодисын агуулах, шатах тослох материалын агуулах ба засварын талбай нь аянгын шууд цохилтоос хамгаалагдсан байна.

1.14. Усан хангамж

Орд ашиглалтын үед унд ахуйн усыг төслийн талбайгаас 2.5 км зайд орших гүний худагтай гэрээ байгуулан, зөөврөөр хангана.

Төслийн нийт усны хэрэглээ: Дарханы барилгын чулууны ордын Хадат хэсгийн барилгын чулууны ордыг ашигласан усны хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ

Ашиглалтын жил	Усны хэрэглээ /мян.мЗ/			
	Уурхайн кемп, ахуйн хэрэглээ	Зам усалгаа	Ногоон байгууламжийн усаагаа	Нийт
1 дэх жил	21.6	1,390.32	384	1,795.92
2-22 дахь жил	830.1	30.587 04	1,536.00	32,953.14
Нийт	830.5	31,977.36	1,920.00	34,727.86

БҮЛЭГ 2. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт нь байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах зорилт тавьж ажиллана.

Газрын гадарга:

- Овоолго зам талбай бусад байгууламжаар газрын гадарга өөрчлөгдөх,
- Уурхайн ухааш, овоолго үүсэхэд газрын хэвлий эвдэгдэх,
- Газрын хэвлийд үүсэх орон зай нь мал амьтан аюултай байдал үүсэх.

Агаарын чанар:

- Ашиглагдах тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээс ялгарах нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материалын ууршилт, автомашины хөдөлгүүрээс ялгарах хорт нэгдлүүд нь агаарыг бохирдуулах,
- Дайрга олборлох, хөрс хуулах, тээвэрлэлтийн явцад агаарт тоосжилт үүсэх,
- Уурхайн олборлолт, тэсэлгээний үйл явц, овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаарыг байнга бохирдуулах,
- Олборлолт тээвэрлэлтийн явц, овоолгоос үүссэн тоос шороо агаарт тархаж агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх.

Хөрсөн бүрхэвч:

- Барилга байгууламж байгуулах, ил уурхайн үйл ажиллагааны явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөх.
- Бүтээн байгуулалт болон барилгын чулуу олборлолтын явцад хүнд даацын машин, техникийн хөдөлгөөний улмаас өнгөн хөрс антропогени нөлөөлөлд өртөн, эрүүл талбай хөрсний овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүсэх,
- Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах,
- Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх,
- Хөрс эвдэрч физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах,
- Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах.

Ургамлан нөмрөг:

- Тоосжилт үүссэнээс ургамал ба ургамлын бүрхэвч дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно,
- Олборлолт, барилга байгууламж зэргээс газрын ургамал бүрмөсөн устана,

- Олон салаа зам, машин техникийн замбараагүй зорчих нь сөргөөр нөлөөлнө,

Амьтны аймаг:

- Олборлолтоос үүдэн мал амьтан үргэн дайжих,
- Уурхайн ухааш хоосон орон зайд мал амьтан унаж, бэртэх,
- Амьтан устах, дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг өөрчлөлт нөлөөллөөс үүдэн амьтны аймаг нь аль нэг хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэрэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж зурвас нутгийн орчноос холдоно.

Нийгэм эдийн засаг:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас гарах тоосжилт, ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдал, тоос шороо, чимээ шуугиан.
- Технологийн үйл ажиллагаанаас үүсэх тоосны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушиг болон амьсгалын замын эрхтэнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болдог. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажилласнаас ажилчдын анхаарал сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа алдах зэргээр осол аюултай үр дагаврыг үзүүлнэ.
- Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн 2022 оны БОМТ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан хийгдсэн бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил, уурхайн ашиглалтын хугацаа зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, нөхөн сэргээлт зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

“Дарханы барилгын чулууны ордын Хадатын хэсгийн барилгын чулууны орд” нь 2022 онд 7 сарын хугацаанд олборлолт явуулна. БОМТ-нд 2022 онд нийт 5,286.0 мян.төг зарцуулахаар төлөвлөлөө.

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хариуцах эзэн	Зардал, 2022 он /мян.төг/	Гарах үр дүн
<i>Агаарын орчин</i>					
1	Олборлолтын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж тогтмол усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Тогтмол	Байгаль орчны мэргэжилтэн	Дотоод төлөвлөлт өөр	Тоосжилтоос сэргийлэх
2	Хог хаягдлын цэгийг БО газраар тогтоолгон хашаалах ариутгал халдваргүйжүүлэлт хийх	2022 онд	Байгаль орчны мэргэжилтэн	200.0	Хог хаягдлаас орчинд эвгүй үнэр бий болох хог салхинд хийсэж тарахаас хамгаалсан байх
3	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Жилд 2 удаа	Байгаль орчны мэргэжилтэн	ОХШХ-т тусгагдсан	Агаарын бохирдлыг хянах


4	Хүнд механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх	Тогтмол	Уурхайн удирдлага	60.0*7=420	Автомашинны яндангаас гарах утаа, хөө тортогоос орчин бохирдохоос сэргийлэх
<i>Хөрсөн бүрхэвч</i>					
1	Тээврийн хэрэгслийг маршрутын технолгийн зам дагуу 1,2 км бутлаг ургамал тарих	Уурхайн үйл ажиллагааны явцад	Уурхайн дарга	1.200	Хөрс элэгдэл эвдрэлд орох, олон салаа зам үүсэхээс сэргийлэх.
2	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж, хог хаягдлыг цаг тухай бүрт нь тээвэрлүүлэх	Сар бүр	Уурхайн дарга	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан	Хог хаягдлаар орчин бохирдохоос сэргийлэх
3	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	Тогтмол	Байгаль орчны мэргэжилтэн	-	Хөрс бохирдохоос сэргийлэх
4	Тээврийн хэрэгслийг олон салаа зам гаргахгүйгээр тогтсон нэг маршрутаар явуулах	Тогтмол	Уурхайн дарга		Олон салаа зам гарч, хөрс элэгдэл эвдрэлд өртөхөөс сэргийлэх
5	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Олборлолт эхлэхийн өмнө	Уурхайн дарга		Өнгөн хөрсийг нөхөн сэргээлтэнд ашиглах.
<i>Усан орчин</i>					
1	Унд ахуйн усны шинжилгээг жил бүр шинжлүүлэх.	Жил бүр	“Уулс ноён” ХХК	ОХШХ-т тусгагдсан	Унд ахуйн усны эрүүл ахуйн шаардлага
2	Ахуйн хэрэглээний усыг ил задгай асгахгүй байх,	Тогтмол	“Уулс ноён” ХХК		Хөрс, орчин бохирдохоос сэргийлэх
Нийт дүн			1,820		

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 4-р заалтын биелэлтийг хангах зорилгоор бид төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгсэл, автомиксерийн засвар, оношлогоог мэргэжилийн хүмүүсээр буюу засварчин, засварын газруудаар

хийлгэдэг болно. 2022 оны байдлаар энэхүү оношлогоо засварын ажилд 613,000 төгрөгийн зардлыг гаргаад байна.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 2-р заалтын биелэлтийг орон нутагтай хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж тогтсон хувиарын дагуу төслийн талбайн байршлаас тээвэрлүүлэн зайлуулж байгаа.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 3-р заалтын биелэлтийг хангахын тулд шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах шаардлага гараагүй бөгөөд нэг үгээр бол төслийн талбай орчимд шатах тослох материал алдагдаагүй бөгөөд хадгалалтанд байнга хяналт тавьж ажиллаж байгаа.



Зураг 2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 5-р заалтын биелэлт

Төслийн үйл ажиллагаа эхлэх үе шатанд буюу тухайн чулууны ордыг ашиглаж эхлэхийн өмнө тухайн талбайгаас шимт хөрсийг хуулан авч 1.5-1.8 м өндөртэй шимт хөрсний овоолго байдлаар үүсгэн, тухайн шимт хөрсний үржил шимийг алдуулахгүй хадгалах болон тухайн гадаргаас хөрснөөс үүсэх тоосонцорын хэмжээг бага байлгах зорилгоор олон наст ургамлыг тарьж ургуулсан болно. Тухайн талбай нь нийт 3,384 м² талбайтай байх бөгөөд карейр хэсгийн чанх урд талд нь байрлаж байна.



Зураг 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 4-р заалтын биелэлт

Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техникүүдийг замын тоосжилт бага байх, хөрсний эвдрэлд өртөх талбайн хэмжээг бага байлгах үүднээс бүтээгдхүүн тээвэрлэлтийн замыг 2 ургалтай байхуйц өргөнтэй(2 машин зөрөх боломжтой)

техникийн шороон замаар ачаатай үед хурдны дээд хязгаарыг 30 км, ачаагүй үед 35 хүртэлх км/цаг хурдтай явах тухай анхааруулга тэмдгийг төслийн талбайн замын ойролцоо байршуулсан болно.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний **2-р заалтын биелэлтийг** хангаж ажиллахын тулд нийт ажилчдад ундны усыг асгахгүй, аль болох хэмнэлттэй ашиглах, унд ахуйгаас өөр зориулалтаар онц шаардлагагүй тохиолдолд ашиглахгүй байх талаар зааварчилгаа өгч ажиллаж байна.

3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уурхайг ашиглаж дууссаны дараа буюу ашиглалтын 22 жилийн дараа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ гэж БОННУ-ий тайланд тусгагдсан учир хийгдэхгүй.

3.3. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй.

3.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Дархан-Уул аймаг Дархан сумын 5-р багийн нутагт Төв цэвэрлэх байгууламж явах замын баруун талд орших 0.5 га талбайд хог хаягдалыг зөөж цэвэрлэн шимт хөрсөөр хучиж 20-30ш мод тарина. Дүйцүүлэн хамгаалах зардал 900 мян.төг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах талбайн координат

Цэгийн дугаар	Солбицлууд	
	Уртраг	Өргөрөг
1	105° 55' 21.32"	49° 30' 1.79"
2	105° 55' 26.80"	49° 30' 3.66"
3	105° 55' 31.46"	49° 29' 57.16"
4	105° 55' 29.52"	49° 29' 26.80"
5	105° 55' 25.72"	49° 30' 2.63"
6	105° 55' 22.54"	49° 30' 1.11"

Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршлын хажууд байрлах хуучин хогийн цэг байдлаар ашиглаж байсан талбайн нийт орчинд тархсан хогийг ковш ашиглан түрэлт хийн цэвэрлэж тухайн орчныг шимт хөрсөөр хучсан бөгөөд одоогоор тус талбайд байгалийн жамаараа олон наст ургамал ургаж байна.

Мөн 2022 оны төлөвлөгөөнд тухайн талбайд мод тарихаар төлөвлөгөө боловсруулж шуудуу байдлаар нүх бэлдэж үрсэлгээний модны нүх, тогоолсон байдлаар модны нүхийг ухаж бэлтгэсэн. Энэхүү 2022 онд бидний төлөвлөснөөр тухайн талбайн ногоон байгууламжийг нэмэх ажил хийх болсонтой холбоотойгоор тус талбайд мод тарих ажлыг хийсэн бөгөөд нийт 20 модыг хаврын улирал, нэмэлтээр 200 ш хайлаас, 83 ш нарс модыг суулгаад байна. Энэхүү ажлыг “Уулс ноён” ХХК-тай хамтран хийв.



Зураг 4. Дүйцүүлэн хамгаалах талбайн зураг

3.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хуулийн Тавдугаар бүлгийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт

гаргуулна”. 27,9-д “Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалд авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна гэсний дагуу хайгуулын ажлын явцад ордын эзэмшлийн талбайд нийт 36 булш оршуулгын дурсгал, хиргисүүр илэрснийг тойруулан төмөр хайсаар хашаажуулах ажлыг 2019 онд хийж гүйцэтгэсэн учир 2022 онд хашаа хамгаалалтын арчилгааны ажил хийгдэхээр төлөвлөв.

3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Уулс ноён” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллана.

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, 2021 он /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	ХАБЭА	Тогтмол		-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 - MNS 5002-2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй -MNS 005-1985, хөдөлмөр хамгаалал, шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд
2	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	“Уулс ноён” ХХК	Жил бүр уурхай эхлэх үед	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан	
3	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайн удирдлага	Уурхайн кемп орчимд		
4	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	ХАБЭА	Тогтмол		
5	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	ХАБЭА	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө		
6	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	“Уулс ноён” ХХК	Жилд 1 удаа	300.0	
Нийт			300.0		

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 1-р заалтын биелэлтийг Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний 4-р заалтын биелэлтээр хангагдсан бөгөөд тухайн биелэлтийг хангах зорилгоор бид төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгсэл, автомиксерийн засвар, оношлогоог мэргэжилийн хүмүүсээр буюу засварчин,

засварын газруудаар хийлгэдэг болно. 2022 оны байдлаар энэхүү оношлогоо засварын ажилд 613,000 төгрөгийн зардлыг гаргаад байна.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний **2-р заалтын биелэлтийг** хангах зорилгоор онцгой байдлын газрын ажилтан албан хаагч нараас зааварчилгаа зөвөлгөө авч түүний хэрэгжүүлэх зорилгоор хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай хамтатган өгч ажиллаж байна.



Зураг 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт

Төслийн үйл ажиллагаа явагдаж буй талбайн байршил орчимд гал унтраах багаж хэрэгслийг гал гарах хамгийн өндөр магадлалтай байж болохуйц талбайтай ойр байхаар тооцож гаргасан. Гэхдээ тухайн төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгсэл нь галын аюул гарах магадлал маш бага бөгөөд цахилгаанаар ажилладаг, мөн тухайн байршилд кемп байрлаагүй бөгөөд зөвхөн харуул хамгаалалтын ажилчдын байр байгаа нь тухайн эрсдэл гарах орчин нөхцөлийг бууруулж байгаа юм.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө **4-р заалтын биелэлт** болох хүчтэй салхи шуургатай үед төслийн үйл ажиллагааг зогсоох тохиолдол нь харилцан адилгүйгээр байна. Энэ нь хэрэв аймгийн онцгой байдлын газраас хориг тавих, онцгой байдал зарлах тохиолдолд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсдог. Харин энгийн шуургатай өдрүүдэд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа үргэлжлэн явах бүрэн боломжтой бөгөөд манай уурхайд ажиллаж буй технологи нь салхи шуурганы нөлөөлөлд төдийлөн өртөж, цаг агаарын байдлаас хамааралгүйгээр ажиллах бүрэн боломжтой технологи юм.

Зураг 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 5-р заалтын биелэлт

Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайд ажиллах нийт ажилчид, бие бүрэлдхүүнийг ажилд гарахаас нь өмнө зааварчилгааг өгч, зааварчилгаатай танилцсан ажилчдыг гарын үсэг зуруулж ажилд гаргадаг.



Зураг 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний 6-р заалтын биелэлт



Зураг 8. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажилчдад олгосон байдал

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалттай хамтатган зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтанд “Анто од” ХХК-ийн удирдлагууд болон ХАБЭА-ийн ажилтнууд болон бүх ажилтнуудтай хамт тухайн сургалтанд өөрсдийн ажилчдаа хамруулсан болно.

3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдал нь ахуйн хатуу хог хаягдал (хуванцар сав, шил, лааз, цаас, сав, баглаа боодол, ахуйн хэрэглээ гэх мэт), шингэн хаягдал (уурхайн хотхоны хэрэглээнээс хаягдах бохир ус, хоолны газар, усанд орох газар гэх мэтээс гарах бохир ус гэх мэт), аюултай хог хаягдал (хэрэглэсэн шатах тослох материал, тээврийн хэрэгсэлээс гарах дугуй, резин, ашигласан зай гэх мэт)-ын сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой ажиллана.

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардал, 2022 он /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
1	Ахуйн хатуу хог хаягдал хаях цэгийг Хонгор сумын засаг даргаар тогтоолгосны дагуу төвлөрсөн цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэх	Уурхайн дарга	Сар бүр	40.0*7=280	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/
2	Кемп орчимд хогийн савнууд суурилуулж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ялгах, тэмдэгжүүлэх, төвлөрсөн хогийн цэгт зориулалтын хогийн сав байрлуулах	Уурхайн дарга	Уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө	900.0	
3	Хог хаягдлын төвлөрсөн цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих	Уурхайн дарга	Үйл ажиллагааны явцад	280,0	
4	Аюултай хог хаягдлыг зориулалтын газарт хадгалж аюултай хог хаягдлыг дахин боловсруулах уйлдвэр лүү тээвэрлүүлэх	Уурхайн дарга	Үйл ажиллагааны явцад	Дотоод төлөвлөлт-өөр	
Нийт дүн				1.460	

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний **1-р заалтын биелэлтийг** 2022 онд нийт 72,000+208,500+19,000 төг гэх мэт зардлыг 1 жилийн хугацаанд гаргаад байна. Энэхүү зардал нь нийтдээ 289,500 төгрөгийн зардал гараад байна.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний **2-р заалтын биелэлтийг** хангах боломжгүй бөгөөд тухайн төслийн үйл ажиллагаанд кемп байхгүй, мөн ажилчидын ахуйн хэрэглээнээс гарах хаягдал нь цөөн тоотой ундаа, усны сав, тамхины хайрцаг, тамхины иш гэсэн хог хаягдалаас өөр тухайн талбайд хог хаягдал одоогоор гарахгүй байна.



Зураг 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт

Хог хаягдлын цэгийг шийдвэрлэхдээ төслийн үйл ажиллагаа явагдаж буй байршилд хогийн цэгийг тойруулан хашаа барьж тухайн хашаанд өөрдсийн гарын доорх материалыг ашиглан хогийн сав хийсэн. Төслийн үйл ажиллагаанд дээр дурьдсанчлан кемп байхгүй, ажилчдын хоолыг Дархан-аас тээвэрлэж авж ирдэг тул хоолны хаягдал гардаггүй тул том оврын хогийн сав байрлуулах шаардлагагүй.

Аюултай хог хаягдлыг “Анто Од” ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн аюултай хог хаягдал хүлээн авах талбайд очиж моторын тос, бусад нефтийн бүтээгдхүүний шингэнг сольдог. Хэрэв тухайн байршилд очиж сольж чадахгүй, уурхайн байршилд солих тохиолдолд тухайн аюултай хаягдлыг битүүмж сайтай саванд хадгалж удаалгүй зөөвөрлөдөг. Аюултай хог хаягдлыг зориулалтын газарт хадгалж, аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх заалтын дагуу ажиллаж байгаа ба тухайн аюултай хог хаягдал хадгалах цэгийг суурь хэсгээр нь бетондож тухайн хаягдлыг хадгалах талбайн хязгаарлалтыг тогтоон 1.5 м өндөртэй төмөр, нарийн хэрээстэй төмрөөр хашаа хийж, хаягдал тосны болон бусад нефтийн бүтээгдхүүний хаягдлыг тусдаа хадгалж байна. Мөн тухайн талбайн хаягдал тосны агууламжаас хамаарч тээвэрлэлт хийх, үгүй нь шийдвэрлэгддэг бөгөөд одоогоор хаягдал хадгалах савны хэмжээ нь 50%-ийн дүүрэлттэй байгаа бөгөөд 75%-аас дээш болсон тохиолдолд Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайн эзэмшигч байгууллага болох “Уулс ноён” ХХК-ийн хаягдал тос хүлээн авах тусгай зөвшөөрөлтэй (аюултай хог хаягдал) аж ахуй нэгж болох “Хай Би Ойл” ХХК-тай байгуулсан гэрээг ашиглан тухайн хаягдал тосыг тээвэрлүүлэхээр төлөвлөж байна.

3.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Дарханы барилгын чулууны ордын Хадатын хэсгийн барилгын чулууны орд”-ыг олборлох явцад байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд үүнд төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэн шаардлагатай арга хэмжээнүүд байхаар байна.

Зураг 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, 2021 он /мян.төг /
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх, шинэчлэн засварлах. байгаль орчны асуудал хариуцсан ажилтантай болох	Тогтмол	Уурхайн дарга	Дотоод төлөвлөлтөөр
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилд 1 удаа	“Уулс ноён” ХХК	300.0
3	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Жил бүр	“Уулс ноён” ХХК	40.0*18=720.0
Нийт дүн			1,020	

1. Уурхайн үйл ажиллагааны Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний явцад байгаль хамгаалах ажил зайлшгүй хийх шаардлагатай болдог бөгөөд энэхүү ажлыг хийхэд тухайн чиглэлээр ажиллах, үүрэг даалгавар өгөх, тухайн чиглэлээр хийсэн ажлыг тайлагнах гэх мэт цөөнгүй ажил гардаг бөгөөд түүнийг хийх ажилтан нь мэргэжлийн байх шаардлагатай болдог. Иймд манай компани нь өөрийн байгууллагатаа байгаль орчны чиглэлээр ажиллах боловсон хүчин авах шаардлагатай болсон тул Ц.Баатар /3394120510/-ийг байгаль орчны ажилтнаар ажилд авсан болно. /ажилтны- Дипломыг хавсралтаар оруулав/
2. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний **2-р заалтын биелэлт** нь осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний 2, 6-р заалтын биелэлтээр хангагдсан.

АЖИЛЧДЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН ТАЙЛАН

Цээнэ эмнэлэгт Анто Од ХХК-ны 24 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаас эрүүл 10, зүрх судасны эмгэгтэй 4, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй 5 / ходоодны үрэвсэлтэй 1, нойр булчирхайн үрэвсэл 1, цэсний хүүдийн үрэвсэлтэй 1, цэсний чулуутай 2 / Бөөр, шээсний замын эмгэгтэй 3, чихрийн шижинтэй 2, бусад /шамбарам, тулай/ 2 нийт өвчлөл 16 илэрсэн. Хүн бүрт нарийн мэргэжлийн эмч нар зөвлөгөө өгч, эмчилгээг зааж өгсөн. Онош, эмчийн зөвлөгөөг хавсаргав.

№	Нэр	Регистерийн дугаар	Онош	Зөвлөгөө
1 ✓	Хастуяа.Б	АЮ63032168	Е11 чихрийн шижин, К80 цэсний чулуу	Хоолны дэглэм барих, мэс заслын эмчид үзүүлж зөвлөгөө авах
2 ✓	Энхмаа.Т ✓	МБ94071502	Z00 Эрүүл	
3 ✓	Анар-Эрдэнэ.Л ✓	ТД82042211	М 10 Тулай	Лампурын 1x2 14 хоног уух
4 ✓	Туяа.М	ТИ69073060	N11 Бөөрний үрэвсэл	Нефрис 2x2 10 хоног уух
5 ✓	Байгаль.Д	МТ82060501	I11 Даралт ихсэх өвчин	Предизин 35 мг 1a3 10 хоног уух, Амлодипин 5мг 1x1 уух
6 ✓	Бадам.З	ТЕ91070441	K29 Ходоод 1 нугалаа гэдэсний үрэвсэл	Пантопрозол 20 мг 1x1 хоолны өмнө уух
7 ✓	Батцэрмаа.П	ТД77092407	Z00 Эрүүл	Хоолны дэглэм барих
8 ✓	Бямбадорж.Г	ПЖ88012212	К80 Цэсний чулуутай	Мэс заслын эмчийн зөвлөгөө авах,
9 ✓	Эрдэнэцэцэг.Б	ТИ87071608	Z00 Эрүүл	
10 ✓	Жамсрансүрэн.Б	РУ98051813	Z00 Эрүүл	Аспирин магни кардио 100 мг 1x1 уух
11 ✓	Байгалмаа.Б	ЕЮ77111801	N11 Бөөрний үрэвсэл	Канефорон 1x3 10 хоног, Фурудонин 2x3 уух
12 ✓	Лувсаншарав.Г	ТГ62050373	I11 Даралт ихсэх өвчин	Лориста 100 мг 1x1 тогтмол уух, Аторис 20 мг 1x1 өдөрт 1ш-р 3 сар уух
13 ✓	СэрОд.М	ТЕ84071675	I 25 Зүрхний ишемийн өвчин	Предизин 1x3 10 хоног уух Аспирин магникардио 1x1 1 сар уух
14 ✓	Шинэбаяр.Н	ТЛ90010178	I 84 Шамбарам	Жин хасах, хоолны дэглэм барих, дасгал хөдөлгөөн хийх
15 ✓	Батсайхан.Ч	ДЭ79101915	К82 Цэсний хүүдийн үрэвсэл	Урсоман 250 мг 1x2 14 хоног уух, Хоолны дэглэм барих
16 ✓	Дашдорж.Ц	ТК61100117	К86 Нойр булчирхайн үрэвсэл	Дажес 1x3 10 хоног уух
17 ✓	Нямсүрэн.Х	РЙ66020611	Е11 чихрийн шижин, N11 бөөрний үрэвсэл	Жин хасах, хоолны дэглэм барих, дасгал хөдөлгөөн хийх Сахарын шинжилгээ давтан өгөх
18 ✓	Мөнхбаяр.М	ТЕ74030410	Z00 Эрүүл	

19 ✓	Баасандорж.Б	ИЧ75082912	Z00 Эрүүл	Магни В6 1x3 уух
20 ✓	Сандагжав.Т	ИВ63031816	I 25 Зүрхний ишемийн өвчин	Предизин 35 мг 1x3 10 хоног уух
21 ✓	Батбаяр.Ү	МУ89110671	Z00 Эрүүл	
22 ✓	Хадхүрэл.Б	ТГ95011713	Z00 Эрүүл	
23	Хишигчулуун.О	МТ63092618	Z00 Эрүүл	Магнимон 400 мг 1x1 уух
24 ✓	Бэхбат.Б	ТГ81040899	Z00 Эрүүл	Жин хасах, хоолны дэглэм барих, дасгал хөдөлгөөн хийх
25	Ж.Отгонханд ✓	МЮ89050367		ирээгүй

НЭГТГЭСЭН
СТАТИСТИКЧ *Г.Эрдэнэчимэг*

ХЯНАСАН
ЕРӨНХИЙ ЭМЧ *Ю.ОЮУН*

Зураг 11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний 3-р заалтын биелэлт

Нийт ажилчидыг жил бүрийн эмнэлэгийн оншилгоо үзлэгт хамруулан ажиллаж байгаа бөгөөд 25 ажилтан эчмийн үзлэгт орох ёстой байснаас 24 ажилтанг эмчийн үзлэгт оруулав.

3.9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

“Уулс ноён” ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Олон нийтэд танилцуулах төлөвлөгөө

БОМТ тайлагнах, байгууллагууд	хэрэгжилтийг хэлэлцүүлэх	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Дархан-Уул аймаг	Багийн ИНХ	Хураанд танилцуулах	БОМТ-ийн 2022 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Багийн төв
	Сумын ЗД, БОХХБайцаагч	Уулзалт			Сумын төв
Төрийн захиргааны төв байгууллага	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2022 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	УБ хот

3.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.

Уг ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ий тайлан, БОМТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган ажиллана.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Уулс ноён” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулна.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№.	Хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналтын хугацаа, давтамж	Зардал, 2022 он /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын орчин					
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM ₂₅) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO ₂ , SO ₂ , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Уурхай орчмоос	Жилд удаа 1	Шинжээчийн зардал 150.0 + 25.0 * 1цэг 1 удаа=175.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 2009:5014 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
Усан орчин					
1	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Унд ахуйн уснаас	Жилд удаа 1	2021оны 1-р улиралд 46.0*1 удаа=46.0.	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS0900 : 2005 Ундны ус. Эрүүл Усны түвшин (газрын гадаргаас ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Хөрсөн бүрхэвч					

1.	Хөрсний морфологи бичиглэл, РН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр.	Уурхай орчмоос	Жилд удаа	1	Ерөнхий шинжилгээ-1цэг* 1удаа=65.0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
Нийт дүн					286.0	

3.10.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний үр дүн

Хүснэгт 12. Агаарын шинжилгээний үр дүн 1-р

№	Шинжилгээний аргачлал	Агаарын шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 4585:2016 1 удаагийн сорьцын ХА	Хэмжилт хийсэн цэг
					ХАДАТ
1	MNS17.2.5.12:1988	Хүхэрлэг хий /SO ₂ /	мкг/м ³	450	2
2	MNS17.2.5.11:1988	Азотын давхар исэл	мкг/м ³	200	15
3	MNS4048-88	Нийт тоосонцор /20 мин/	мкг/м ³	500	1200

3.10.3. Усны чанарын хяналт шинжилгээ ба түүний үр дүн

Төслийн үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа худгийн ус ашиглаагүй, цэвэршүүлсэн ус болон Сэрүүн нэртэй усыг “Ассесмент групп” ХХК-аас худалдан авч ашигладаг.



3.10.3. Хөрсний чанарын хяналт шинжилгээ ба түүний үр дүн

Хүснэгт 13. Хөрсний шинжилгээний үр дүн 1-р

№	Шинжилгээний аргын стандарт	Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 3297:2019 ЗДХ	ХАДАТ

1	MNS3310:91	Хөрсний ялзмаг	%		1.70
2		Нитрат, NO ₃	мг/кг	130	18.7
3		Сульфат, SO ₄	мг/кг	160	16.1
4		Аммони, NH ₄	мг/кг		18.1
5		PH			7.21
6		ЕС	μS/cm		174.3

4. 2021 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ

“Уулс ноён” ХХК-ийн 2022 оны БОМТ-нд нийт мян.төг зарцуулах зардал.

№	Биелэлтийн зориулалт	Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	472,000+322,000= Нийт зардал: 794,000
2	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	Нөхөн сэргээлт хийгдэхгүй
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нийт зардал	Өөрсдийн дотоод зардлаар үрсэлгээ хийж мод тарих арга хэмжээ хийгдсэн
4	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажил	
5	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний ажлын биелэлт	1,143,500
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний ажлын биелэлт	299,500
7	Орчны хяналт шинжилгээний ажлын зардал	146,500
8	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	Дотоод зардлаар
9	Нөлөөллийн бүсийн иргэд, БОМТ-г сонирхогч талуудад танилцуулах ажлын биелэлт	Дотоод зардлаар
2022 оны БОМТ-ний биелэлтийн нийт зардал		2,383,500 төгрөг+ дотоод зардал гарсан байна.

Хавсралт материал

1. Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ
3. Газрын карастр
4. Ерөнхий үнэлгээний дүгнэлт
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний батлагдсан нүүр /5жилийнх/
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний батлагдсан нүүр
7. Хаягдал тосны гэрээ
8. Бусад төлбөрийн баримтууд